

ЯПОН УЛС ЗУУН МЯНГАН ХҮН ХҮЛЭЭЖ  
АВАХ ЧАДАЛТАЙ «САРНЫ ХОТХОН»  
БАЙГУУЛНА

Японы Обояши гэдэг барилгын компани 1988 онд огторгуйд анхдагч сарны хотхон байгуулах гэж байгаагаа зарлав. Сансар дахь хот байгуулалтын ажил дууссаны дараа саран дээр очиж ажиллах ба амьдрах зуун мянган хүнийг хүлээн авч болох ба бас дэлхийгээс аялал жуулчлалаар саран дээр очих мөн шинжилгээ судалгааны ажил хийх хүмүүсийг хүлээж авах бололцоотой болох гэнэ.

Төлөвлөсөн ёсоор энэхүү «сарны хотхон»-ыг саран дээр байгаа асар том галт уулын аманд байрлуулах ба сансрын орон сууцны цогцолбороос бүрдэх гэнэ. Бүх хотыг барих ажлыг 2050 онд дуусгах бодолтой байгаа гэнэ.

Барилгын Обояши компанийн мэргэжилтнүүдийн мэдээлснээр бол саран дээрхи шороо чулууны дээжийг авч судалгаа явуулаад саран дээр байгаа чулуу, элс зэрэг нь шил, цемент зэргийг үйлдвэрлэх бэлэн түүхий эд юм байна гэдгийг тогтоогоод, энэ компани нь саран дээр зөвхөн цемент, шил зэрэг барилгын түүхий эд үйлдвэрлээд зогсохгүй саран дээр төмөр хайлуулж, цэнгэг ус найруулж болох юм гэдгийг тогтоожээ.

«Сарны хотхон» байгуулахын тул Японы өөр нэгэн том компани дэлхий ба сарны хооронд ирж очиж байх галт тэрэгний цуваа явуулах төсөл зохиох бэлтгэл хийж байгаа бөгөөд одоогоор саран дээр буух цэгийг сонгох ажил хийж байна. Тэр үед сарны тэнхлэг нь жуулчны төв болох бололтой.

Орчуулсан Г. ГУНГАА